

Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн маягт

1	Мэдэгдэл огноо	Он	2021	Сар	03	Өдөр	31
2	Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр	БОДЬ ДААТГАЛ ХК					
3	Даатгалын бүтээгдэхүүний нэр	БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХАРИУЦЛАГЫН ДААТГАЛ					
4	Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр	Хариуцлагын даатгал					
5	Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр	Шийдвэрийн нэр		Огноо		Дугаар	
		Даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулах тухай		2021.03.31		ТУЗ/2107	
6	Цахимаар борлуулах эсэх	<input checked="" type="checkbox"/> Тийм <input checked="" type="checkbox"/> Үгүй					
7	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Овог		Нэр			
		Балсан		Баярмагнай			
Мэдээллийн төрлийг сонгоно уу.							
8	Даатгалын бүтээгдэхүүнийг шинээр борлуулах <input checked="" type="checkbox"/> Даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэх						
Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл							
9	Даатгалын зүйл	Даатгуулагчийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн болон үзүүлсэн үйлчилгээний шууд үр дүнгээс шалтгаалан үйлчлүүлэгчийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд учруулсан хохирлын өмнө хүлээх хуулийн хариуцлага					

	Даатгалын үндсэн эрсдэл	<p>Дараах эрсдэлийн улмаас бүтээгдэхүүн үйлчилгээнд хохирол учирч гуравдагч этгээдэд урчуулсан хохирол нь даатгалын үндсэн эрсдэл байна:</p> <ol style="list-style-type: none"> 1. Хүнсний, эм, эмнэлгийн хэрэгсэл, гоо сайхны бүтээгдэхүүн болон бусад бүх төрлийн тоног төхөөрөмжийг технологи, горим стандартын дагуу үйлдвэрлэх, хадгалах болон тээвэрлэх зориулалттай машин, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, сав, баглаа боодолд гадны нөлөөлөх хүчин зүйлээс (ус, чийг гэх мэт) шалтгаалж тухайн бүтээгдэхүүнд өөрчлөлт үүсэх, урвалд орох, чанар муудах эрсдэл; 2. Экспорт ба импортын бараа бүтээгдэхүүний тээвэрлэлтийн явцад үүсэх сааталтаас шалтгаалж бүтээгдэхүүний хугацаа хэтрэх эрсдэл; 3. Импортын бараа бүтээгдэхүүнийг хил гаалиар шалгагдах хугацаанд зориулалтын бус, ариун цэвэр, эрүүл ахуйн байдал хангаагүй газар хадгалах мөн урт удаан хугацаагаар саатуулж, хадгалсан зэргээс бүтээгдэхүүний хугацаа хэтрэх, чанар муудах, бүтцэнд өөрчлөлт орох эрсдэл; 4. Тоног төхөөрөмж үйлдвэрлэгч, нийлүүлэгч байгууллагын ажилчдын санамсаргүй болгоомжгүй үйлдлээс шалтгаалж буруу угсрах, чанарын дутагдалтай бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлсэн, борлуулсанаас үүдэх эрсдэл; 5. Үйлдвэрлэгдсэн болон нийлүүлэгдсэн үйлдвэрлэлийн машин тоног төхөөрөмжийн алдаанаас шалтгаалж бүтээгдэхүүний гологдол гарах, стандартын шаардлага хангахгүй бараа бүтээгдэхүүн гарах эрсдэл;
	Даатгалын нэмэлт эрсдэл	
	Даатгалын хураамжийн хувь, хэмжээ	0.5 -4.0 хувь

ДААТГАЛД ХАМРАГДАХГҮЙ НӨХЦӨЛ

1. Даатгалын тухай хуулийн 8.5-д заасан үндэслэл бүрдсэн;
2. Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон химийн бодисыг импортлох, тээвэрлэх, хадгалах, ашиглах журам, шаардлагыг зөрчсөн тохиолдолд;
3. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм, үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны журам зааврыг зөрчсөнөөс үүдэн гарсан хохирол;
4. Даатгуулагчийн эрхэлж буй үйл ажиллагаа нь зохих лиценз, үйлчилгээ эрхлэгч этгээд үйл ажиллагаа явуулах бүх шаардлагатай зөвшөөрлийн баримт бичиг, дүгнэлтийг мэргэжлийн хяналтын алба болон бусад зохих албанаас аваагүй, тусгай зөвшөөрөлгүй тохиолдолд гарсан аливаа хохирол, гэрээний үндсэн нөхцөлд заагдаагүй үйл ажиллагаанаас учирсан эрсдэл, даатгагдаагүй үйл ажиллагааны улмаас учирсан хохирол;
5. Химийн бодис импортлохдоо холбогдох мэргэжлийн хяналтын байгууллагад мэдэгдэх, тухайн экспортлогч орны эрх бүхий байгууллагаас олгосон гэрчилгээ болон гэрээг үндэслэн зөвшөөрөл авсан байх, бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуй, аюулгүй байдлын үзүүлэлтүүд нь олон улсын болон үндэсний стандартад нийцсэн байх;
6. Бүтээгдэхүүний дээжид холбогдох байгууллагаар шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулсан байх;
7. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт зориулалтын байр, тоног төхөөрөмжөөр хангагдсан байх мөн үйлдвэрлэлийн дамжлагыг технологийн дагуу удирдан хөтлөх, хянах;

8. Химийн бодисын сав баглаа боодлын шошго стандартын шаардлага, чанарын баталгаа хангасан байх, мөн түүнийг тээвэрлэх тээврийн хэрэгсэл, хадгалах агуулах, ашиглах ажлын байрны тодорхойлолт, анхааруулах тэмдэгт тавигдах шаардлагыг хангасан байх;
9. Мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байх, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн гаргахдаа түүнд орсон түүхий эд материалын бүтэц, чанар, тухайн бүтээгдэхүүний техникийн тодорхойлолтыг хавсаргасан байх;
10. Монгол улсын бүртгэлд бүртгэгдээгүй, зохих байгууллагын зөвшөөрөлгүй бүтээгдэхүүнийг импортлох, худалдах, чанарын баталгаагүй түүхий эд, материалаар химийн бодис үйлдвэрлэх, тухайн бүтээгдэхүүнээр
11. Хохирол учирсан талаар эрх бүхий байгууллага даатгагчид нэн дариу мэдэгдэн шалгуулаагүй болон бусад шалтгаанаар даатгалын зүйлд хохирол учирсан шалтгаан тогтоогдоогүй, тодорхой бус байх;
12. Нөхөн төлбөрийн баримтуудыг хүлээлгэж өгөх, нөхөн төлбөрийн нэхэмжлэлийн хүлээлгийн хугацаа дуусгавар болсноос хойш нөхөн төлбөрийн нэхэмжлэл хүргүүлсэн;
13. Сайн дураар төлсөн болон хүлээн зөвшөөрсөн төлбөр, хохирол, төлбөрийн чадваргүй болох эрсдэл; торгууль, шийтгэвэр, төрийн байгууллагаас ногдуулсан шийтгэвэр;
14. Даатгуулагчийн ажилтан согтууруулах, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсний улмаас учирсан хохирол, гэмт хэргийн шинж чанартай аливаа хохирол;
15. Үйлчлүүлэгчийн гаргасан нэхэмжлэлийг шийдвэрлэх шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд даатгагчийг оролцох боломжоор хангаагүй;
16. Шалган турших, судалгаа, шинжилгээний ажлын явцад учирсан хохирол;
17. Аливаа гэрээний хариуцлага /Даатгуулагчийн үйл ажиллагаатай холбоотой аливаа гэрээний үүрэг биелүүлэхтэй холбоотой хариуцлага, түүнээс үүдэн гарсан хохирол;/
18. Даатгуулагчийн бүтээгдэхүүн ба байгаль орчинд учруулах хохирол /Даатгуулагчийн өөрийн үйлдвэрлэн борлуулж буй бүтээгдэхүүний улмаас учирсан хохирол;/
19. Өөрийн хөрөнгийн хохирол /Даатгуулагчийн эзэмшил, түрээс, зээл, хараа хяналтад байгаа хөрөнгөнд учирсан хохирол;
20. Даатгуулагч гал, эрчим хүч, ус, дулаан, цахилгаан, сантехник ашиглалт, аюулгүй ажиллагааны хууль тогтоомж, ашиглах дүрэм, заавар, стандарт зөрчсөнөөс үүссэн хохирол,
21. Техник тоног, төхөөрөмжийн ашиглалтын дүрэм, арчилгааны заавар зөрчсөн, ажиллах даац, ачаалал хэтрүүлснээс үүссэн хохирол;
22. Газар доогуурх уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэн гарах хохирол;
23. Монгол улсын нутаг дэвсгэрээс гадна явуулсан үйл ажиллагаанаас учирсан хохирол;
24. Дайн, дайн бүхий байдал, зэвсэгт бослого, байлдааны зэвсэг хэрэглэх, үймээн самуун, террорист үйл ажиллагаа, бослого, ажил хаялт, төрийн захиргааны байгууллагын акт шийдвэр, улс төрийн тэмцэлд оролцсон, цөмийн дэлбэрэлт, цацраг идэвхт бодис буюу туяаны хордлого;
25. Хууль тогтоомжинд заасан бусад үндэслэлүүдээр даатгагч тус даатгалын нөхөн төлбөр олгох үүрэг хүлээхгүй.